



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/078/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 229

танай 2025.01.23-ны № 2 -т

Г ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ө.ЦЭВЭЭНСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн код зөрүүтэй сонгосноос 339.5 мянган төгрөгийн шимтгэлийг ажилтнаас төлсөн, Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага 1,531.5 мянган төгрөгт тооцоо нийлсэн акт үйлдээгүй, Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн холбогдох тогтоол, шийдвэргүй 418,874.9 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч бүртгэлд тусгасан, байгууллагын удирдлагын тушаал шийдвэргүй 27,831.8 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данснаас хассан, 73,516.5 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээнд нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт хавсаргаагүй, гэрээг дүгнэж акт үйлдээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно, 39.3.2-т Гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, 48 дугаар зүйлийн

011022091

48.2.9-т Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 6.4.8-д Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	346,366,416.33	431,915,493.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	216,773,210.30	308,451,275.39
31211	Төрийн сангийн харилцах	216,773,210.30	308,451,275.39
33	АВЛАГА	-	1,531,587.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,531,587.64
35	БАРАА МАТЕРИАЛ	129,593,206.03	121,932,630.03
351	Түүхий эд материал	18,964,766.47	19,729,631.67
35110	Тусгай зориулалттай материал	18,006,266.47	18,771,131.67
35130	Эм боох материал	958,500.00	958,500.00
354	Хангамжийн материал	110,628,439.56	102,202,998.36
35420	Аж ахуйн материал	44,750,509.16	60,127,804.16
35460	Хүнсний материал	3,447,732.20	
35470	Бусад хангамжийн материал	62,430,198.20	42,075,194.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,494,296,719.25	2,049,083,774.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,494,296,719.25	2,049,083,774.27
392	Биет хөрөнгө	1,468,528,719.25	2,003,315,774.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,521,824,576.65	2,035,948,957.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(209,785,500.12)	(262,525,635.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	190,800,223.90	169,716,043.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(114,303,868.36)	(59,968,846.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,252,127.22	119,104,957.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,137,694.02)	(30,996,747.18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	121,224,342.00	139,918,392.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(102,135,486.52)	(110,671,345.88)
39217	Номын фонд	2,789,998.50	2,789,998.50
393	Биет бус хөрөнгө	25,768,000.00	45,768,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,768,000.00	45,768,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,840,663,135.58	2,480,999,267.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	10,268,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	10,268,000.00
413	Өглөг	-	10,268,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	10,268,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,840,663,135.58	2,470,731,267.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1,840,663,135.58	2,470,731,267.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	411,893,287.87	411,893,287.87
512	Хуримтлагдсан үр дүн	1,004,048,802.62	1,634,116,934.37
51210	Өмнөх үеийн үр дүн	862,968,485.40	1,004,048,802.62
51220	Тайлант үеийн үр дүн	141,080,317.22	630,068,131.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	424,721,045.09	424,721,045.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,840,663,135.58	2,480,999,267.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,083,554,767.61	1,906,335,701.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,035,445,567.61	1,839,531,901.60
120	Нийтлэг татварын бус орлого	146,073,067.61	652,799,301.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,261,658.00	414,035,781.00

**Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,473,500.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	118,788,158.00	414,035,781.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	16,188,196.50	216,445,905.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	8,623,213.11	22,317,615.20
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	889,372,500.00	1,186,732,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	889,372,500.00	1,186,732,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,109,200.00	66,803,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,678,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,403,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	45,431,200.00	61,400,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	942,474,450.39	1,276,163,369.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,474,450.39	1,276,163,369.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,818,053.19	1,231,607,144.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629,179,770.76	868,930,542.11
210101	Үндсэн цалин	458,369,436.61	561,208,476.08
210102	Нэмэгдэл	152,240,655.96	279,220,177.33
210104	Урамшуулал	18,569,678.19	28,501,888.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,170,849.81	107,386,169.42
210201	Тэтгэврийн даатгал	54,253,608.89	73,280,503.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,250,921.25	8,461,879.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,463,221.59	5,251,244.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,160,780.40	3,950,535.06
210205	Эрүүл мэндийн даатгал	12,042,317.68	16,442,007.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,900,000.00	50,607,052.80
210301	Гэрэл, цахилгаан	8,300,000.00	8,999,752.80
210302	Түлш, халаалт	34,300,000.00	39,123,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,300,000.00	2,483,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,093,153.00	6,996,855.00
210401	Бичиг хэрэг	5,093,153.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		6,996,855.00
2105	Нормативт зардал	38,709,239.28	25,034,455.29
210502	Хоол, хүнс	38,709,239.28	25,034,455.29
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,644,200.00	10,399,094.00
210604	Урсгал засвар	1,644,200.00	10,399,094.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,353,500.00	8,201,490.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,473,500.00	614,600.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,880,000.00	7,586,890.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,767,340.34	154,051,485.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,233,277.00	44,629,333.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,198,650.00	8,795,720.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,335,413.34	100,626,431.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,656,397.20	44,556,225.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,656,397.20	44,257,071.82
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,656,397.20	44,257,071.82
2134	Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	-	299,153.20

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		299,153.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	141,080,317.22	630,172,331.91
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)	-	104,200.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	104,200.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		104,200.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	141,080,317.22	630,068,131.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	939,955,200.00	1,253,536,400.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	939,955,200.00	1,253,536,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	891,846,000.00	1,186,732,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,473,500.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,473,500.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	2,473,500.00	
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	889,372,500.00	1,186,732,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	889,372,500.00	1,186,732,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,109,200.00	66,803,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,678,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,403,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,431,200.00	61,400,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	45,431,200.00	61,400,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	884,721,152.25	1,161,858,334.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	884,721,152.25	1,161,858,334.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,661,995.25	1,119,458,311.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	629,179,770.76	870,462,129.75
210101	Үндсэн цалин	458,369,436.61	562,740,063.72
210102	Нэмэгдэл	152,240,655.96	279,220,177.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210103	Урамшуулал	18,569,678.19	28,501,888.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,170,849.81	107,386,169.42
210201	Тэтгэврийн даатгал	54,253,608.89	73,280,503.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,250,921.25	8,461,879.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,463,221.59	5,251,244.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,160,780.40	3,950,535.06
210205	Эрүүл мэндийн даатгал	12,042,317.68	16,442,007.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,500,000.00	50,607,052.80
210301	Гэрэл, цахилгаан	8,300,000.00	8,999,752.80
210302	Түлш, халаалт	31,900,000.00	39,123,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,300,000.00	2,483,500.00
2105	Нормативт зардал	30,754,197.68	23,742,925.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол хүнс	30,754,197.68	23,742,925.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,931,200.00	10,493,794.00
210604	Урсгал засвар	1,931,200.00	10,493,794.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,353,500.00	8,201,490.85

**Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,473,500.00	614,600.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,880,000.00	7,586,890.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,772,477.00	48,564,749.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,319,227.00	38,780,629.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,453,250.00	9,784,120.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,059,157.00	42,100,869.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,059,157.00	42,100,869.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		299,153.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		299,153.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	55,234,047.75	91,678,065.09
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	55,234,047.75	91,678,065.09
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,539,162.55	216,773,210.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	216,773,210.30	308,451,275.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	862,968,485.40	0.00	1,699,582,818.36
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	862,968,485.40	0.00	1,699,582,818.36
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	141,080,317.22	0.00	141,080,317.22
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,004,048,802.62	0.00	1,840,663,135.58
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,004,048,802.62	0.00	1,840,663,135.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,004,048,802.62	0.00	1,840,663,135.58
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	630,068,131.75	0.00	630,068,131.75
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	411,893,287.87	424,721,045.09	1,634,116,934.37	0.00	2,470,731,267.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,464,915,400.00	1,161,559,181.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,464,915,400.00	1,161,559,181.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,414,706,800.00	1,119,458,311.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,089,188,200.00	870,462,129.75
210101	Үндсэн цалин	682,081,900.00	562,740,063.72
210102	Нэмэгдэл	403,321,600.00	279,220,177.33
210104	Урамшуулал	3,784,700.00	28,501,888.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,148,400.00	107,386,169.42
210201	Тэтгэврийн даатгал	92,581,000.00	73,280,503.86
210202	Тэтгэмжийн даатгал	10,891,900.00	8,461,879.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,445,900.00	5,251,244.12
210204	Ажилгүйдлийн даатгал	5,445,900.00	3,950,535.06
210205	Эрүүл мэндийн даатгал	21,783,700.00	16,442,007.33

**Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,800,000.00	50,607,052.80
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	8,999,752.80
210302	Түлш, халаалт	41,300,000.00	39,123,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,483,500.00
2105	Нормативт зардал	35,855,400.00	23,742,925.00
210502	Хоол, хүнс	35,855,400.00	23,742,925.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,574,400.00	10,493,794.00
210604	Урсгал засвар	10,574,400.00	10,493,794.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,863,000.00	8,201,490.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	614,600.00	614,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,248,400.00	7,586,890.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,277,400.00	48,564,749.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,445,500.00	38,780,629.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,831,900.00	9,784,120.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,208,600.00	42,100,869.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,208,600.00	42,100,869.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,208,600.00	42,100,869.90
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,464,915,400.00	1,253,237,246.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,186,732,600.00	1,186,732,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,186,732,600.00	1,186,732,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,400,000.00	61,100,846.80
132001	Орон нутгийн төсвөөс	61,400,000.00	61,100,846.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	216,782,800.00	5,403,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	9,589.70	5,403,800.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	216,773,210.30	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	216,773,210.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	308,451,275.39
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66.00	45.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	35.00	23.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	360.00	358.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	360.00	358.00
630001	Төрийн өмчит ЕБС	360.00	358.00

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11,799.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Залруулсан алдаа:

- Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлийн буруу тооцож 1,531.6 мянган төгрөгийн авлага үүсгэн, тайлан балансад тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Тус байгууллага нь утасгүй интернэтийн төхөөрөмж худалдан аваад байгууллагад төлөх үлдэгдэл 10,268.0 мянган төгрөгийг өглөгөөр тусгаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 524.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 529.9 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.4 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

2.1 Албан шаардлага

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогчид 100 хувь, няравт 60.0 хувиар тооцон 2.2 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлагын үлдэгдэлтэй гарсныг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн оршин байх ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн холбогдох тогтоол, шийдвэр гараагүй байхад орлого авч бүртгэлд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн оршин байх ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Байгууллагын даргын тушаалгүй эргэлтийн хөрөнгийг акталсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн оршин байх ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
5. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хийгээгүй, тендер шалгаруулалтын процессыг баримтжуулаагүй боловч оролцогчтой худалдан авалтын гэрээ хийсэн байна. Худалдан авалтын үйл ажиллагаа хангалтгүй, гэрээ байгуулсан огноо, дугаар, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа алдаатай тусгагдсан байна. Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т "Худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг", 48 дугаар зүйлийн 48.4.6-д "Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж", 48.2.9-д "Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Зөвлөмж

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НДШ-ийн тайлантай холбоотой

Илрүүлэлт: НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн код зөрүүтэйгээс 8 ажилтны код зөрүүтэй тайлагнаснаас ажилтнаас илүү суутгал хийсэн. Энэ нь УСНББОУС 01, нийцсэн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн кодыг тулган ижил болгох.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
НДШ-ийн авлаг тусгаагүй	1	1,531.6	1	1,531.6			-	-	-	-	-	-
Байгууллагад төлөх өглөг тусгаагүй	1	10,268.0	1	10,268.0			-	-	-	-	-	-
Дүн	2	11,799.6	2	11,799.6			-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогчид 100 хувь, няравт 60.0 хувиар тооцон 2.2 сая төгрөгийг олгосон	1	2,206.5			1	2,206.5							

Дорнод аймгийн Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлагын үлдэгдэлтэй гарсныг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	1,531.6			1	1,531.6					
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн холбогдох тогтоол, шийдвэр гараагүй байхад орлого авч бүртгэлд тусгасан	1	418,874.9			1	418,874.9					
Байгууллагын даргын тушаалгүй эргэлтийн хөрөнгийг акталсан	1	27,831.9			1	27,831.9					
Худалдан авалтын үйл ажиллагаа хангалтгүй, гэрээ байгуулсан огноо, дугаар, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа алдаатай тусгагдсан байна. Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй	1	73,516.5			1	73,516.5					
НДШ-ийн тайлан, Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн систем дэх ажил мэргэжлийн код зөрүүтэйгээс 8 ажилтны код зөрүүтэй тайлагнаснаас ажилтнаас илүү суутгал хийсэн.	1	339.5					1	339.5			
Дүн	6	524,300.9			4	523,961.4	1	339.5			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд хугацаа хоцорсон 4, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.	1	-					1	-
Нийт дүн	1	-					1	-



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 1029/1925799
2025-02/029/4А-СТА-ТМБ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үнэ төлбөргүй хүлээн авсан 418,874,979.60 төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэргүйгээр тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн дансанд орлогоор бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ", 27 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно"., Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчидтавигдах шаардлага, шалгуур журам"-ын 4.1.2-т "Тухайн салбар, байгууллагын аж ахуй, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны бүртгэлийн батлагдсан загвар аргачлалын дагуу бүртгэж, баримтын бүрдэлтэд хяналт тавих", 4.1.3-т "Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

2125040270

1. Эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийг үндэслэн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг тайлант хугацааны үндсэн хөрөнгийн орлогод хүлээн авч бүртгэх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх


2. Хууль тогтоомж, холбогдох шийдвэрийг баримтлан ажиллахыг Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Э.Энх-Отгон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 131/19425795
АВА - 2025/048/НА - ОТА - ТУС

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах 73,516,500.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хийгээгүй, тендер шалгаруулалтын процессыг бүрэн баримтжуулаагүй, гэрээний нөхцөлд заавал тусгах огноо, дугаар, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа алдаатай байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх" зарчим, 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.2-т "гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл", 48 дугаар зүйлийн 48.2.7-т "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 48.2.9-т "Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах", 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 дэх "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах, худалдан авах гэрээнд тусгах нөхцлүүдийг бүрэн тусгасан байх холбогдох баримтыг бүрэн бүрдүүлэх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040275

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Э.Энх-Отгон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 228/19125799
АА - 2025/028/НА - СТА-ТМБ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл 1,531,587.00 төгрөгийн илүү төлөлтийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 4.1.6-д "Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт, эд хөрөнгийн улирал, жилийн тооллогын бүртгэл, тооцоо бодсон актыг үндэслэн санхүүгийн тайлан тэнцэл гаргаж, батлагдсан төсвийн гүйцэтгэл, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн илтгэх хуудасны хамт Төсвийн тухай хуулийн 8.8, 8.9, 8.10-т заасан хугацаанд холбогдох байгууллагад хүлээлгэн өгч байх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.2-т "Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан авах буюу дараа төлөх шимтгэлд шилжүүлэн тооцуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалын хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.4-т "Ажил олгогч нь тайлангийн өглөг, авлагын үлдэгдлийг сар бүр хянаж, жил бүрийн 06 дугаар сарын 30, 12 дугаар сарын 31-ний өдрийн дүнгээр нийгмийн даатгалын байцаагчтай цахимаар тооцоо нийлж баталгаажуулна"- гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.7 дох "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй", 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

2125040266

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, харилцагч байгууллагатай хуулийн хугацаанд тооцоо нийлж баталгаажуулж байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Э.Энх-Отгон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 124/19125199
АВА - 2025/0787 НА -СТА - ТУУС

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч, нярав нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,206,500.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040764

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Э.Энх-Отгон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

 И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 124/1942.5749
2025-2025/049/НА-СТА-ТМЗ

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч, нярав нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 2,206,500.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040263

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Э.Энх-Отгон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 130/19625799
АВА - АВАГ/ВАХ/НА - СТА - ТУЗ

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургуулийн захирлын тушаал, дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр 27,831,859.00 эргэлтийн хөрөнгийг акталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 3-т “Дотоодын тооллогын тайлан тэнцлийн дүнг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүү, статистикийн байгууллагатай хамтран улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж, дутагдсан эд хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэл болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн эд хөрөнгийг шилжүүлэх, борлуулах, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч Засгийн газарт тайлагнана”, 73 дугаар зүйлийн “Эд хөрөнгийн тооллого явуулах журам”-ын 2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4.1.3-т “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 271 тоот тогтоолын хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 8.1-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

2125040484

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Эрх бүхий байгууллагын хяналт, сургуулийн захирлын тушаалыг үндэслэн эргэлтийн хөрөнгийг данснаас хасах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Хууль тогтоомж, холбогдох шийдвэрийг баримтлан ажиллахыг Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ө.Цэвээнсүрэн, нягтлан бодогч Э.Энх-Отгон нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ

